



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 04 сарын 10 өдөр

Дугаар А/175

Чингис хот

Хөл хорио тогтоож урьдчилан сэргийлэх
арга хэмжээ авах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4, 10.7, 32 дугаар зүйлийн 32.1.1, Засгийн газрын 2021 оны 45, 91 дүгээр тогтоол, Улсын Онцгой комиссын 2021 оны 02 дугаар тогтоол, Аймгийн Онцгой комиссын 11 дүгээр хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хэрлэн, Дэлгэрхаан сумдад Коронавируст халдвар /COVID-19/-ын шинэ голомт батлагдсан тохиолдол илэрсэн тул дээрх хоёр сумын нутаг дэвсгэрийн хэмжээнд хатуу хөл хориог 2021 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн 20:00 цагаас 2021 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн 00:00 цаг хүртэлх хугацаанд тогтоож холбогдох журмыг хангуулж ажиллахыг Цагдаагийн газар /хурандаа Б.Батсайхан/, Мэргэжлийн хяналтын газар /Б.Сүнгээ/, сумдын Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

2. Коронавируст халдвар /COVID-19/-ын батлагдсан тохиолдлын хавьтал бүхий иргэдийн судалгааг гаргаж, түргэвчилсэн болон ПГУ-ын шинжилгээнд хамруулж хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн газар /Л.Мэндбаяр/, Тагнуулын хэлтэс /дэд хурандаа Н.Алтангэрэл/, Хэрлэн, Дэлгэрхаан сумдын Онцгой комиссын дарга нарт үүрэг болгосугай.

3. Хатуу хөл хорио тогтоосон хугацаанд иргэдэд түлш, ус, нэн шаардлагатай хүнс, ахуйн хэрэглээний бараа, эм, эмийн бүтээгдэхүүнийг хүргэлтээр хангах арга хэмжээг шуурхай зохион байгуулж ажиллахыг дээрх сумдын Засаг дарга нарт даалгасугай.р

4. Бүх нийтийн бэлэн байдлын үеийн халдвар хамгааллын дэглэмийг чанд мөрдөж, аймаг сумдын онцгой комиссын шийдвэрийг хэрэгжүүлэхийг нийт иргэдэд, бараа үйлчилгээний үнийн хөөрөгдөл, зохиомол хомсдол үүсгэхгүй байж, халдвар хамгааллын дэглэмийг мөрдлөг болгон ажиллахыг аж ахуйн нэгж байгууллагын дарга, захирал нарт үүрэг болгосугай.

5. Зөвшөөрөлгүй болон батлагдаагүй замаар зорчсон, хуурамч бичиг баримт ашигласан, асуумжийг худал мэдүүлсэн зэрэг зөрчил гаргасан иргэдийг шалгаж шийдвэрлүүлэх, шалган нэвтрүүлэх цэгүүдийн хяналтыг чангатгаж ажиллахыг Цагдаагийн газар /цагдаагийн хурандаа Б.Батсайхан/-т үүрэг болгосугай.

6. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч /Ц.Чогсомжав/, Шуурхай штабын дарга /хурандаа Ж.Эрдэнэбат/-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ИДЭРБАТ

231011529